

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ТУСГАЙ ШАЛГАЛТЫН ЗАР

2026.01.16

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1.2 дахь заалтад заасны дагуу төрийн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд хамаарах бүтцийн нэгжийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт /цаашид “удирдах албан тушаалын тусгай шалгалт”/-нд төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага

1. Хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
2. Сэтгэцийн өвчин эмгэггүй байх;
3. Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх;
4. Тайлбар: 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадалгаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд Төрийн албаны тухай хуулийн 22.1.6-д заасан шаардлага хамаарахгүй.
5. Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;
6. Төрийн албанд эргэж орох эрхгүйгээр хугацаа зааж халсан эсхүл албан тушаал эрхлэх эрх хязгаарласан шүүхийн тогтоолтой бол уг хугацаа дууссан байх;
7. Иргэний хувьд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх;
8. Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

1. Төрийн албан хаагчийн анкет;
2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
3. Намтар
4. Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
5. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
6. Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, цахим лавлагаа;

7. Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн дүнгийн хуудас;
8. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia -аас авах).

Тусгай шаардлага:

1. Доорх мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
 - 1.1. Нягтлан бодох бүртгэл /0411/;
 - 1.2. Санхүү /0412/;
 - 1.3. Эдийн засаг /0311/;
 - 1.4. Менежмент ба удирдахуй /0413/;
 - 1.5. Эрх зүй /0421/
2. Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх.
3. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн байх.
4. Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.
5. Нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх.

Материал хүлээн авах:

1. Хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 09:00 цагаас 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл
2. Хүлээн авах хаяг: baganuur@ndaatgal.mn цахим шуудангаар
3. Холбоо барих утас: 70210021-6; 90063306